



ТАТВАРЫН ЕРӨНХИЙ ГАЗРЫН ДАРГА  
Т.БАТМАГНАЙ ТАНАА

МОНГОЛ УЛСЫН  
ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР  
АЛБАН ШААРДЛАГА

210646 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,  
Бага тойруу, Засгийн газрын IV байр,  
Утас: 26-04-37, Факс: 32-32-66

2013.03.25 № 05/39 УТ-САГ/2013/011-СТА-ТТЗ

Зөрчил арилгуулах тухай

Татварын ерөнхий газрын 2012 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд аудит хийх явцад дараах зөрчил илэрлээ. Үүнд:

- Гадны байгууллагын ажилтнуудыг 5.0 сая төгрөгөөр шагнасан байна.
- Татварын ерөнхий газрын даргын 2012 оны 135 дугаар тушаалаар Сангийн яамны нэр бүхий 6 ажилтанд тус бүр орон сууц олгохоор сертификат олгосон байна.

Эдгээр шагнал урамшуулал нь Татварын ерөнхий газрын даргын 2009 оны 56 дугаар тушаалаар баталсан “Үндэсний татварын албаны албан хаагчид шагнал урамшуулал олгох журам”-ыг зөрчиж байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 15.1.12-д “аудитын явцад илэрсэн төлбөр, зөрчлийг барагдуулах акт тавих, албан шаардлага өгөх”, Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2009 оны 47 дугаар тушаалаар баталсан “Төлбөрийн акт тавих, албан шаардлага өгөхөд баримтлах журам”-ыг үндэслэн дээрх алдаа зөрчлийг зогсоож, цаашид давтан гаргахгүй ажиллах, Сангийн яамны нэр бүхий 6 ажилтан нарт орон сууц олгохоор өгсөн сертификатыг хүчингүй болгохыг Татварын ерөнхий газрын дарга Т.Батмагнай, ерөнхий санхүүч Л.Бямбадорж нарт үүрэг болгож албан шаардлага хүргүүлж байна.

Албан шаардлагын биелэлтийг 2013 оны эхний хагас жилд багтаан Үндэсний аудитын газарт ирүүлэхийг мэдэгдье.

Аудитор



Д.Гандолгор

070114